

Тэргүүлэх чиглэл 1: Тавантолгой-Гашуунсухайт”

чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт

2021-2024 он

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

Суурь бүтцийн бүтээн байгуулалт ба ашиглалт

ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛУУД:

1. Төмөр замын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх төр, засгийн шийдвэрийн хэрэгжилтийг хангах;
2. Төмөр замын суурь бүтцийг өөрийн хүч хөрөнгөөр барих үйл ажиллагааг удирдан зохион байгуулж дуусгах;
3. Төмөр замын суурь бүтцийг барих үйл ажиллагааг менежментээр хангах, захиалагчийн хяналт тавьж, шаардлагатай нөөцүүдийг цаг тухайд нь төвлөрүүлэн ажиллах;
4. Төмөр замын суурь бүтцийг хүлээн авч, зүгшрүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
5. Хөдлөх бүрэлдэхүүнийг худалдан авах, зүгшрүүлэх;
6. Төмөр зам, түүний бүх төрлийн үйлчилгээнд шаардлагатай мэргэжлийн хүний нөөцөөр нэгдсэн бодлого, төлөвлөлттэйгөөр тогтвортой үйл ажиллагаа явуулах;

ГОЛ ҮР ДҮН:

- 2020 оны 07 дугаар сар гэхэд “Таван толгой-Гашуунсухайт” чиглэлийн 240 км төмөр замыг ашиглалтад оруулна.
- Уг төмөр зам дагалдах зарим объектууд ашиглалтад орсон байна.

2025-2030 он

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

Бизнесийн цогц үйл ажиллагаанд суурилагдсан төмөр зам

ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛУУД:

1. Уг чиглэлийн төмөр замын ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлд суурь бүтцийн хөгжлийг хангаж ажиллах;
2. Тээвэрлэлтийн өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээг хангах түвшинд засвар үйлчилгээний дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, хүний нөөцийг хөгжүүлэх;

ГОЛ ҮР ДҮН:

Чанарын шаардлага хангах засвар үйлчилгээг бие даан гүйцэтгэх тогтолцоо төлөвшиж, хүний нөөцийн чадавх хөгжсөн байна.

Тэргүүлэх чиглэл 2: Төмөр замын зүүн коридорын бүтээн байгуулалт

ЗОРИЛГО: Зүүн бүсийн төдийгүй хөрш орнууд, олон улсын төмөр замын тээврийн

2021-2024 он

2025-2030 он

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

“Чойбалсан - Хөөт - Бичигт” чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт

ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛУУД:

1. Төмөр замын шаардлагатай бүхий л үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг баталгаажуулж, зүүн коридорыг босоо тэнхлэгтэй холбох төмөр замын суурь бүтцийг барих, ашиглах;
2. Шаардлагатай төслүүдийн судалгааны ажлуудыг гүйцэтгэх, мэдээллийг цуглуулах, бодлого, эрх зүйн баримт бичгийг боловсруулах, баталгаажуулах;
3. Бүтээн байгуулалтын санжүүжилтийг оновчтой эх үүсвэрээс шаардлагатай хэмжээгээр хангах;
4. Төмөр замын оновчтой, аюулгүй тээврийн болон цогц үйлчилгээний үйл явц бүрд олон улсын нийтлэг жишигт нийцсэн дүрэм, журам, стандарт, тариф, удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, боловсронгуй болгох

ГОЛ ҮР ДҮН:

“Чойбалсан - Хөөт - Бичигт” чиглэлийн 417 км төмөр замыг барьж дууссан байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

Гурван улсын төмөр замын зүүн коридорыг төлөвшүүлэх үе

ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛУУД:

1. Гурван улсын эдийн засгийн коридорын төмөр замын суурь бүтцийг барьж дуусгахад идэвхтэй оролцох;
2. Аж үйлдвэрийн цогцолборыг барих;
3. Төмөр замын зүүн коридорын шаардлагатай дэд бүтцүүдийг бий болгох;
/Тухайлбал, цахилгаан станц, сургууль, цэцэрлэг, ажиллагсдын орон сууц, ажлын байр гэх мэт/

ГОЛ ҮР ДҮН:

- “Чойбалсан – Хөөт – Бичигт” (417 км) чиглэлийн төмөр замын суурь бүтцийг ашиглаж эхэлнэ.
- Зүүн босоо коридорын хэмжээнд тээвэрлэлтийн үйл ажиллагаа эхэлсэн байна.

Тэргүүлэх чиглэл 3: Төмөр зам, үйлчилгээ

ЗОРИЛГО: Төмөр замын ба түүний тээврийн цогц, чанартай үйлчилгээг үзүүлж,

2021-2024 он

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

Суурь бүтэц, тээвэрлэлтийн үйлчилгээ

ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛУУД:

- 1.“Тавантолгой - Гашуунсухайт” болон түүнд холбогдох чиглэлийн төмөр замын оновчтой, аюулгүй тээврийн цогц үйлчилгээг хангах дүрэм, журам, стандарт, тариф, удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, боловсронгуй болгох;
- 2.Ачааны эх үүсвэр, төрлөөс үл хамааран төмөр замын тээврийн тасралтгүй, аюулгүй, найдвартай үйл ажиллагааг эрхлэх;
- 3.Тээврийн өсөн нэмэгдэх хэрэгцээ, төмөр замын салбарын бодлогын дагуу хөдлөх бүрэлдэхүүний парк бүрдүүлэх, үе шаттайгаар хөгжүүлэх;
- 4.Суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний засвар үйлчилгээг нэгдсэн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх;
- 5.Тээвэр зохион байгуулалтад орчин үеийн дэвшилтэт техник, технологи, менежментийн аргуудыг хэрэглэх;
6. Суурь бүтцийн болон тээврийн үйлчилгээ эрхэлсэн албадуудад удирдлагын тогтолцооны олон улсын стандартуудыг нэг загвараар хэрэгжүүлэх “Чанарын удирдлагын тогтолцоо” хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх;

ГОЛ ҮР ДҮН:

“Тавантолгой - Гашуунсухайт” чиглэлийн болон түүнтэй холбогдох төмөр замын сүлжээнд суурь бүтэц ашиглалт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг бие даан эрхлэн явуулах түвшинд хүрсэн байна.

2025-2030 он

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

Тээвэр логиستيкийг түшиглэсэн төмөр замын цогц үйлчилгээ

ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛУУД:

- 1.Ачаа тээврийн зохион байгуулалт, хөдлөх бүрэлдэхүүний засвар, үйлчилгээ, зам, дохиолол холбоо, эрчим хүч, ус хангамжийн ажилчдыг бэлтгэх, давтан сургах сургалтыг нэгдсэн удирдлага, хүний нөөцийн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх;
- 2.Төмөр замаар үйлчлүүлэгчид хэрэглэгчид болон хамтран ажилладаг байгууллагуудын сонирхлыг дээшлүүлэх талаар шинжлэх ухааны үндэслэлтэй арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх;
- 3.Бүх төрлийн үйлчилгээндээ гадаад дотоодын шилдэг туршлага, дэвшилтэт техник, технологийг хэрэглэх, хэвшүүлэх;
4. Олон улсад тэргүүлэгч гадны компаниудын шинэчлэл болон ашиглаж байгаа шинэ технологиудын талаар судалгаа хийх;
- 5.Засвар, үйлчилгээ, логиستيкийн албадын менежментийн тогтолцоог олон улсын стандартуудын түвшинд хүргэх;

ГОЛ ҮР ДҮН:

- Засвар, үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашиг, нэр хүндээрээ салбарын байгууллагуудаа манлайлах түвшинд хүрсэн байна.
- Холбогдох олон улсын стандартуудыг ханган ажиллах түвшинд хүрсэн байна.

Тэргүүлэх чиглэл 4: Логистикийн үйл ажиллагаа

ЗОРИЛГО: Компанийн үйл ажиллагааг холбогдох дэд бүтцийн хөгжлөөр дэмжсэн

2021-2024 он	2025-2030 он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ: Логистикийн дэд бүтэц ба үйлчилгээ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛУУД: 1.Тавантолгойн бүсэд логистикийн дэд бүтэц, терминалуудыг барих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхлэх. Үүнд: - Тавантолгой өртөөний ачилтын тойрог замд ТТ-ГС, ТТ-ЗБ чиглэлд нүүрс ачих ажиллагааг зохион байгуулах - Ачилт, буулгалтын терминал барих 2.Гашуунсухайт өртөө болон Ганц мод боомтод нүүрс ачих, буулгах байгууламжуудыг барих. Үүнд: - Гашуунсухайт өртөөнд нүүрс буулгах өндөр зам барих; - Гашуунсухайт боомтод ачих, буулгах терминал, шилжүүлэн ачих байгууламж барьж, ашиглалтад оруулах; 3.Олон улсын тээвэр зууч, логистикийн үйлчилгээг эхлүүлэх; 4. Олон улсын тээвэр зууч, тээврийн компани, терминал, логистикийн үйлчилгээний болон бүс нутгийн уул уурхайн компаниудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх; ГОЛ ҮР ДҮН: • Төмөр замын тээвэрлэлтийг гүйцэтгэх дэд бүтцийн болон логистикийн байгууламжуудыг үе шаттайгаар ашиглалтад оруулсан байна. • Ачих болон буулгах терминал, шилжүүлэн ачих байгууламжуудад тулгуурласан логистикийн үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн байна.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ: Логистик үйлчилгээнд тулгуурласан төмөр замын үйлчилгээ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛУУД: 1.Ачих, буулгах байгууламж, терминалуудын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах, үр ашигтай удирдан зохион байгуулах, засвар үйлчилгээний бааз, мэдээллийн системийг бүрдүүлэх; 2.Хөндлөн, зүүн босоо коридорын дагуух логистик үйлчилгээний хөгжлийн хөтөлбөр боловсруулах ба терминал, ачилт, буулгалтын байгууламжийг барьж, ашиглалтад оруулах; 3.Логистикийн материал, мэдээлэл, санхүүгийн менежментийн нэгдсэн тогтолцоог төгөлдөржүүлэх; 4.Логистикийн үйл ажиллагааг гүйцэтгэсэн ажлынхаа орлогоор санхүүжүүлэх зарчимд шилжүүлэх; 5.Логистик үйлчилгээг цахимаар гүйцэтгэх; ГОЛ ҮР ДҮН: • “Тавантолгой - Гашуунсухайт” дагуух логистикийн дэд бүтэц бүрдэж, олон улсын логистикийн үйл ажиллагаа хэрэгжих орчин болон үйл ажиллагааны чадавхи бүрдсэн байна. • Зүүн босоо коридорын тээвэр, логистикийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн байна.

Тэргүүлэх чиглэл 5: Судалгаа, инноваци

ЗОРИЛГО: Компанид судалгаа, хөгжлийн чадавхыг бэхжүүлж, инновацийн идэвхтэ зорилтот судалгааг өргөжүүлэх замаар нэмэлт орлогын эх үүсвэрийг бүрдүүлж, төмөр замын

2021-2024 он

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

Компанийн судалгааны бүтцийн төлөвшилт

ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛУУД:

- 1.Компанийн болон салбарын хэмжээнд судалгаа хөгжлийн ажлыг гүйцэтгэх чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, хөгжүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ;
- 2.Компанийнүйлажиллагаандшаардлагатай төсөл, баримт бичиг боловсруулахад зөвлөх үйлчилгээ авах судлаачид, мэргэшсэн мэргэжилтнүүдийн сүлжээг бүрдүүлнэ;
- 3.ТХХГ-ыг компанийн төмөр замын цогц үйл ажиллагаа эрхлэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн шинжлэх ухаан, инновацийн түвшинг хангахад зөвлөн туслах чиг үүрэгт чиглэсэн удирдлагын бүтцийн нэгж болгох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ;
- 4.Судалгаа, хөгжлийн үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн мэдээллийн сан үүсгэн хөгжүүлэх, технологийн дэд бүтцийг боловсронгуй болгох ажлыг хэрэгжүүлнэ.

ГОЛ ҮР ДҮН:

Төмөр замын асуудлаар судалгаа хийх мэдлэг, чадвар, туршлага бүхий зураг төсөл, судалгааны чадавхи, түүний дэд бүтэц бүрдсэн байна.

2025-2030 он

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

Судалгаа, инноваци, технологи дамжуулах тогтолцооны хөгжил

ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛУУД:

- 1.Эдийн засгийн коридор, түүний төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой төслүүдийг шинжлэх ухааны өндөр түвшинд боловсруулж ажиллана;
- 2.Төмөр замыг дагасан орон нутаг, түүний зурвас эдийн бүсэд хамрагдаж байгаа бүс нутгийн хөгжлийн стратегийн төлөвлөгөөг боловсруулахад оролцох болон санаачлан ажиллана;
- 3.Байгууллагад дижитал шилжилт хийх хөтөлбөрийг боловсруулж, инновацийг бүх талаар дэмжих орчинг бүрдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ.;
- 4.Компанийн хүрээнд бүрдсэн судалгааны ажлын бүтэц болон зөвлөх, судлаач мэргэжилтнүүдийн сүлжээг тогтвортой ажиллуулна;
5. Олон улсад тэргүүлэгч гадны компаниудын шинэчлэл болон ашиглаж буй шинэ технологиудад судалгаа хийх, мэдээллийн сан үүсгэх, нэвтрүүлэх үйл ажиллагааг хариуцан ажиллана;
- 6.Компанийн судалгааны бүтэц, үйл ажиллагааны чадавхийг салбарын байгууллагуудтай уялдаа холбоонд оруулж эхэлнэ.

ГОЛ ҮР ДҮН:

Компанийн судалгаа, инноваци, технологи дамжуулалтын тогтолцоо төлөвшсөн байна.